



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2012 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 247

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 13.5-ыг үндэслэн хүн амд үзүүлэх сэргээн засах тусlamж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор ТУШААХ НЬ:

- “Чанар, нөөц нь тогтоогдсон рашаан ус, шавар, байгалийн бусад хүчин зүйлийг түшиглэсэн сувиллын үзүүлэх тусlamж, үйлчилгээний журам”-ыг нэгдүгээр, “Рашаан сувилалд эмчлэх, сувилах өвчний жагсаалт”-ыг хоёрдугаар, “Рашаан сувилалд илгээх бичиг”-ийг гуравдугаар, “Сувилуулагчийн түүх”-ийг дөрөвдүгээр хавсралтаар ёсоор баталсугай.
- Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусlamжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д. Гончигсүрэн/, Мэдээлэл-хяналт шинжилгээ, үнэлгээний газар /Д. Жаргалсайхан/т үүрэг болгосугай.
- Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2007 оны 268 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Н. ХҮРЭЛБААТАР



080787

Эрүүл мэндийн сайдын ... оны  
... дугаар сарын 6. өдрийн ... тоот  
тушаалын нэгдүгээр хавсралт

**ЧАНАР, НӨӨЦ НЬ ТОГТООГДСОН РАШААН УС, ШАВАР, БАЙГАЛИЙН  
БУСАД ХҮЧИН ЗҮЙЛИЙГ ТУШИГЛЭСЭН СУВИЛЛЫН ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ,  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хууль, рашаан, сувилалтай холбоотой эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг хангах, хүн амд рашаан, сувиллын тусlamж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлэхэд журмын зорилго оршино.

1.2. Чанар, нөөц нь тогтоогдсон рашаан ус, шавар, байгалийн бусад хүчин зүйлийг тушиглэсэн сувилал /цаашид рашаан, сувилал гэх/-д иргэдийг эмчилж сувилахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

**Хоёр. Сувилуулагч илгээх заавар**

2.1. Сувиллын үйлчилгээг тэгш хүртээмжтэй байлгах, сувилуулагчдын дарааллыг зохицуулах, рашаан сувилалд батлагдсан оноштой сувилуулагч хүлээн авах зорилгоор “Илгээх бичиг”-ийг хэрэглэнэ.

2.2. “Илгээх бичиг”-ийн загварыг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

2.3. “Илгээх бичиг” нь тухайн үйлчлүүлэгчийн мэдээлэл, рашаан, сувилалд эмчлүүлэх үндэслэл, оношийг тусгасан, эмчийн гарын үсэг, байгууллагын даргын гарын үсэг, тамгаар баталгаажсан баримт бичиг байна.

2.4. “Илгээх бичиг”-ийг чанар, нөөц нь тогтоогдсон рашаан ус, шавар, байгалийн бусад хүчин зүйлийг тушиглэсэн сувиллын тусlamж, үйлчилгээ үзүүлж буй рашаан сувилал батлагдсан загвараар хэвлэж, энэ журмын 2.5-д заасан эрүүл мэндийн байгууллагуудад түгээнэ.

2.5. Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх байгууллагууд өвчтөнийг рашаан, сувилалд эмчлүүлэхээр илгээнэ.

2.6. Өвчтөнийг рашаан, сувилалд илгээхдээ “Рашаан сувилалд эмчлэх, сувилах, өвчний жагсаалт”-ын заалтыг баримтлана.

2.7. Рашаан, сувилалд илгээгдэж буй өвчтөний “Илгээх бичиг”-т үндсэн онош, бодит үзлэг, өвчний клиник шинж, хийгдсэн эмчилгээ, хүндрэл, дагалдах өвчин

зэргийг тодорхой бичиж тэмдэглэх ба шаардлагатай лабораторийн болон багажийн шинжилгээний хариуг хавсаргасан байна.

2.8. Нийгмийн даатгалын байгууллагатай даатгалын гэрээ бүхий рашаан, сувилалд эрүүл мэндийн даатгалд даатгуулсан даатгуулагч тусlamж, үйлчилгээ авсан тохиолдолд Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд зааснаар төлбөрийн хөнгөлөлт здэлнэ.

### **Гурав. Рашаан, сувиллын эмчилгээ, сувилгаа**

3.1. Рашаан, сувиллууд нь Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан “Рашаан сувилалд эмчлэх, сувилах өвчний жагсаалт”-д заагдсан оношийн дагуу тусlamж, үйлчилгээ үзүүлнэ.

3.2. Рашаан, сувилалд Эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.6-д заасан тусlamж, үйлчилгээ үзүүлнэ.

3.3. Тусlamж, үйлчилгээг үзүүлэхдээ “Эмчилгээ оношлогсоны түгээмэл үйлдлүүд MNS 4621-2008”, “Рашаан, сувилалд эмчлэх өвчний эмчилгээний удирдамж”, “Сэргээн засах тусlamж, үйлчилгээний оношлогоо, эмчилгээний журам”, “Зонхилон тохиолдох өвчний сэргээн засах оношлогоо, эмчилгээний удирдамж” зэрэг холбогдох эрх зүйн баримт бичгийг мөрдөнө.

3.4. Сувилуулагчийг рашаан, сувиллын хүлээн авахын эмчийн үзлэгт хамруулж, мэдээллийн санд бүртгэсэнээр “Сувилуулагчийн түүх”-ийг нээнэ.

3.5. Эмчлэгч эмч сувилуулагчийн биеийн байдал, эмчилгээний тохирол, үр дүнг хянаж, үзлэгийн тэмдэглэлийг 3 хоног тутамд “Сувилуулагчийн түүх”-нд хөтөлнө.

3.6. Сувилуулах хугацаа дуусахад сувиллын эмчилгээний үр дүнгийн талаар “Сувилуулагчийн түүх”, иргэний эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэл хийж цаашдын эмчилгээ сувилгаа, дэглэмийн талаар зөвлөгөө өгч гаргана.

3.7. Сувилуулагчийг хүлээн аваагүй, буцаасан, эмнэлэгт шилжүүлсэн, сувилуулагч нас барсан тохиолдолд шалтгаан, мэдээллийг тусгай бүртгэлд бүртгэнэ.

### **Дөрөв. Сувилуулагч буцаах заавар**

4.1. Рашаан, сувилалд эмчлүүлж сувилуулахаар ирсэн үйлчилүүлэгчийг дараах тохиолдолд хүлээн авахгүй буюу хугацаанаас нь өмнө буцаана. Үүнд:

4.1.1.“Илгээх бичиг”-т тавигдсан онош, сувиллын хүлээн авах эмчийн оношийн зөрүүтэйгээс эмчлэн сувилах боломжгүй;

- 4.1.2. Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан рашаан сувилалд эмчилж сувилахад хориглох оноштой;
- 4.1.3. Сувиллын эмчилгээнд тухайн өвчтөний өвчний үе шат, хэлбэр, хүндрэл нь харшлахаар байх;
- 4.1.4. Сувилалд эмчлүүлэх явцад өвчин сэдэрч, хүндрэн клиникийн болон төрөлжсөн эмнэлгийн тусламж, үйлчилгээ зайлшгүй шаардлагатай болох;
- 4.1.5. Сувилуулагч сувиллын дотоод журам, дэглэм зөрчих.

#### **Тав. Хүлээлгэх хариуцлага**

- 5.1. Энэ журмыг зөрчсөн албан тушаалтан, байгууллагад Эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

Эрүүл мэндийн сайдын ~~жил~~<sup>оны</sup>  
 дугаар сарын ~~6.~~<sup>6.</sup> өдрийн ~~жил~~<sup>тоот</sup>  
 тушаалын хоёрдугаар хавсралт

### НЭГ. РАШААН СУВИЛАЛД ЭМЧЛЭХ, СУВИЛАХ ӨВЧНИЙ ЖАГСААЛТ

№	Олон улсын ангиллын код	Өвчний нэр	Сувилалд эмчлэх өвчний үе шат, онцлог
<b>Цусны эргэлтийн тогтолцооны өвчин</b>			
1	I 09 I 05 I 06	Хэрлэгийн гаралтай зүрхний архаг өвчнүүд	<p>a/ Анхдагч болон дахих эндокардит, миокардитын хурц, хурцавтар үеэс 6-8 сараас доошгүй хугацаа өнгөрсөн, хэрлэгийн идэвхжилгүй, цусны эргэлтийн дутмагшил I үеэс хэтрээгүй, зүрхний хэм алдагдлын хүнд хэлбэргүй</p> <p>б/ Хос болон гол судасны хавхлагийн гажиг: компенсацийн шатанд, хэрэх өвчний идэвхжилгүй, цусны эргэлтийн дутмагшил I үеэс хэтрээгүй, хэм алдагдалгүй</p>
2	I 41	Зүрхний булчингийн үрэвслэл (миокардит)	Зүрхний булчингийн халдварт, харшлын гаралтай үрэвслээр өвдсөнөөс хойш 6-8 сарын дараа, цусны эргэлтийн дутмагшил I үеэс хэтрээгүй, зүрхний хэм, дамжуулах чадвар алдагдаагүй
3	I 42	Зүрхний булчингийн эмгэг (кардиомиопати)	Цусны эргэлтийн дутмагшил I үеэс хэтрээгүй, зүрхний хэм, дамжуулах чадвар алдагдаагүй
4	I 20	Зүрхний бах (стенокарди)	<p>a/ Дахилт цөөнтэй, хүчдлийн зэрэг /фк/ I-II , цусны эргэлтийн дутмагшил I үеэс хэтрээгүй , зүрхний хэм алдагдлын хүнд хэлбэргүй , артерийн даралт ихсэх өвчин I-II шатнаас хэтрээгүй</p>
5	I 25	Зүрхний архаг ишеми	Зүрхний булчингийн шигдээсээр өвдсөнөөс 1 жилээс доошгүй хугацаа өнгөрсөн, тогтвортой ачааллын стенокарди I-II γ. а. б-ээс хэтрээгүй цусны эргэлтийн дутмагшил I үеэс хэтрээгүй, зүрхний хэм, дамжуулалт алдагдаагүй, артерийн даралт ихдэх өвчин II шатнаас доош
6	I 10	Артерийн даралт ихдэх өвчин	<p>a/ Артерийн даралт ихдэх өвчин I-II шат: тархи, зүрх, бөөрний судас илт хатууран өөрчлөгдөөгүй, зүрхний хэм, дамжуулалт алдагдаагүй, цусны эргэлтийн дутмагшил I үеэс хэтрээгүй</p>

			b/ Зүрхний (хурмал) дутмагшилгүй в/ Бөөрний дутмагшилгүй
7	I 97	Зүрхний мэс ажилбарын дараахь үе	Зүрхний мэс засал ажилбараас 6-8 сар өнгөрсөн, цусны эргэлтийн дутмагшил I үеэс хэтрээгүй, хэрх өвчний идэвхжилгүй болон идэвхжил I үеэс хэтрээгүй
8	I 95	Артерийн даралт багадах	Хүндрэлгүй
9	F 45	Сэтгэлийн болон мэдрэлийн шалтгаант биеийн эмгэг	Зүрх судасны үйл ажиллагааны хямралаар илрэх
10	I 70.2	Атеросклероз	Мөчдийн артерийн атеросклероз, цусны эргэлтийн өөрчлөлтийн компенсаци, субкомпенсацийн шат
11	I 73	Захын артери судасны үрэвсэл	Хүндрэлгүй, эдгэрэлтийн шат
12	I 80.0	Доод мөчний өнгөц судасны флебит ба тромбофлебит	Хүндрэлгүй, эдгэрэлтийн шат

#### Мэдрэлийн тогтолцооны өвчин

1	G 51	Нүүрний мэдрэлийн эмгэг	Хурц үеэс 1,5 сараас дээш хугацаа өнгөрсөн
2	G 54-59	Мэдрэлийн ёзоор, сүлжээ, захын мэдрэлийн эмгэгийн архаг хэлбэр, бүрэн бус намжмал үе	a) Мэдрэлийн ёзоор, сүлжээ, захын мэдрэлийн эмгэгийн архаг хэлбэр, бүрэн бус намжмал үе б) Мэдрэлийн ёзоор сүлжээний дарагдал: мэс заслын эмчилгээ шаардагдахгүй, архаг явцтай, хөдөлгөөн болон аарцгийн эрхтнүүдийн үйл ажиллагаа алдагдаагүй хэлбэр
3	G 60-64	Полиневропати ба захын мэдрэлийн тогтолцооны бусад эмгэг	Янз бүрийн шалтгаант полинейропати эмгэгийн архаг хэлбэр, бүрэн бус намжмал үе
4	I 60-63	Тархины цус харвалт, шигдээс	Цус харvasan болон тархины шигдээсийн дараа 6 сараас доошгүй хугацаа өнгөрсөн, сэтгэц хэвийн, бие даах чадвартай, артерийн даралт тогтвортой байгаа
5	I 69	Тархины судасны өвчний үлдэц	Цус харvasan болон тархины шигдээсийн дараа 1жилээс доошгүй хугацаа өнгөрсөн, артерийн

			дараалт тогтвортой, бусад хүндрэлгүй, сэтгэц хэвийн, өөртэй үйлчлэх чадвар сэргэж буй үе
6	<b>G 45</b>	Тархины цусны эргэлтийн түр зуурын хямрал	Тархины цусны эргэлтийн түр зуурын хямралын дараа 3-4 сарын хугацаа өнгөрсөн
7	<b>S 06</b>	Гавал, тархины гэмтэл	Далд гэмтэл авснаас 4 сар, ил гэмтлийн дараа 4-6 сар өнгөрсөн сэтгэцийн өөрчлөлтгүй, уналтгүй, тархины болон артерийн дараалт ихсээгүй
8	<b>S 14 S 24 S 34</b>	Нугас, мэдрэлийн гэмтэл	Хөнгөн хэлбэрийн тетра, пара, монопарезтай, өөртөө үйлчлэх чадвар сэргэж байгаа болон аарцгийн эрхтний үйл ажиллагаа алдагдаагүй
9	<b>G 43</b>	Мигрень	Хүндрэлгүй
10	<b>G 04 G 05</b>	Энцефалит Миелит	Өвчлөөд 4 сараас доошгүй хугацаа өнгөрсөн, өөртөө үйлчлэх чадвар алдагдаагүй
11	<b>A 80</b>	Полиомиелит	Өвчлөөд 3 сараас доошгүй хугацаа өнгөрсөн өөртөө үйлчлэх чадвар алдагдаагүй
12	<b>G 97.8</b>	Мэдрэлийн мэс заслын дараахь үеийн эмгэг	a/ Нугасанд мэс засал хийлгэснээс 4 сараас доошгүй хугацаа өнгөрсөн аарцгийн эрхтний үйл ажиллагаа алдагдаагүй, өөртөө үйлчлэх чадвартай b/ Захын мэдрэлийн судалд хийсэн мэс ажилбарын дараахь сэргэх үе
13	<b>G 90</b>	Вегетатив мэдрэлийн эмгэг	Вегетативны полиневрит, солярит, ганглионитын хурц үе өнгөрсний дараа
14	<b>F40-48</b>	Мэдрэл сульдал	Сэтгэцийн эмгэг илрээгүй
15	<b>Z 73.0</b>	Хэт ядрах	

#### Хоол боловсруулах эрхтний өвчин

1	<b>K 20</b>	Улаан хоолойн үрэвсэл	Улаан хоолойн архаг үрэвсэл, хурц бус үе
2	<b>K21</b>	Ходоод-улаан хоолойн сөргөө Улаан хоолойн шархлаа	Хөнгөн болон дунд зэргийн, сэдрэлийн бус үе
3	<b>K22</b>	Улаан хоолойн шархлаа	Шархлааны идэвхжилгүй, болон намжмал үе, хүндрэлгүй хэлбэр
4	<b>K25 K26 K28</b>	Ходоод, дээд, өлөн гэдэсний шархлаа	Ходоод, дээд, өлөн гэдэсний шархлааны идэвхжилт буурсан болон намжмал үе, үйл ажиллагааны алдагдалгүй, цус алдалт бусад хүндрэл илрээгүй

5	<b>K 29.3-29.9</b>	Ходоод, дээд гэдэсний үрэвсэл	Архаг үрэвслийн сэдрэлийн бус үе, хүндрэлгүй хэлбэр
6	<b>K58 K59</b>	Нарийн бүдүүн гэдэсний эмгэг	a/ Нарийн бүдүүн гэдэсний сурьеэз, шархлаа, шимэгчийн бус гаралтай архаг үрэвсэл, сэдрэлийн бус үе б/ Гэдэсний үйл ажиллагааны хямрал /дискинез/
7	<b>K66</b>	Хэвллийн наалдац	Хэвллийн хөндийн хагалгаа, үрэвслийн дараа үүссэн наалдац
8	<b>K80 K81 K83</b>	Цөсний хүүдий, цөсний сувгийн эмгэг	a/ Цөсний хүүдий, цөсний замын архаг үрэвсэл, сэдрэлийн бус үе б/ Цөсний хүүдийн үйл ажиллагааны алдагдал в/ Цөсний чулуушралын мэс заслын эмчилгээ шаардлагагүй хэлбэр
9	<b>K-73</b>	Элэгний архаг үрэвсэл	a/ Элэгний үрэвслийн идэвхжилгүй буюу идэвхжил буурсан үе
10	<b>K-86</b>	Нойр булчирхайн архаг үрэвсэл	a/ Нойр булчирхайн архаг үрэвслийн хөнгөн, дунд хэлбэр, сэдрэлийн бус үе
11	<b>K-91</b>	Хоол боловсруулах эрхтний мэс заслын дараахь үе	a/ Ходоод дээд гэдэсний шархлаанд мэс засал хийлгэснээс 2 сараас доошгүй хугацаа өнгөрсөн, шарх бүрэн эдгэрсэн үе б/ Цөсний замд мэс засал хийлгэснээс 3 сараас доошгүй хугацаа өнгөрсөн, шарх бүрэн эдгэрсэн, мэс заслын дараахь хам шинжийн илрэлтэй

#### Амьсгалын тогтолцооны өвчин

1	<b>J12- 18</b>	Уushiгны үрэвсэл	a/ Архаг хэлбэр, сэдрэлийн бус үе, амьсгал, зүрхний дутлын I үеэс дээшгүй
2	<b>J 41-42 J44</b>	Гуурсан хоолойн үрэвсэл	a/ Архаг хэлбэр, сэдрэлийн бус үе
3	<b>J 45</b>	Гуурсан хоолойн багтраа	a/ Багтрааны сэдрэлийн давтамж цөөн, амьсгалын дутагдал II шатнаас доош б/ Багтрааны намжмал үед амьсгал зүрхний дутмагшил II үе шатнаас хэтрээгүй
4	<b>J 47</b>	Бронхо эктази	Хөнгөн хэлбэр, амьсгал зүрхний дутмагшил I үе шатнаас хэтрээгүй
5	<b>J 60-64</b>	Уushiг тоосжих өвчин	Амьсгал, зүрхний дутмагшил I шатнаас хэтрээгүй
6	<b>J68.0</b>	Химиийн бодис хий утаа, уур амьсгалаас үүсэх бронхит, пневмони	Архаг хэлбэр, намжмал үе

7	J 94	Уушигны гялтан хальсны үрэвсэл	Хуурай ба шүүдэст үрэвслийн дараахь намжмал үе, наалдац үүссэн тохиолдол
---	------	--------------------------------	--

### Шээс, бэлгийн эрхтний өвчин

1	N 03 N 04 N 05	Бөөрний архаг нефритийн хам шинж, Түүдгэнцрийн архаг үрэвсэл	a/Архаг гломерулонефрит, бөөрний үйл ажиллагаа хадгалагдсан эсвэл бага зэрэг буурсан, артерийн даралт хэт ихсээгүй б/ Сүрьеэ, чихрийн шижингийн бус гаралтай нефroz хам шинж: бөөрний үйл ажиллагаа хадгалагдсан эсвэл бага зэрэг буурсан, илэрхий гипопротейнемигүй болон протейнуригүй, анемигүй, хавагналт багатай, артерийн даралт хэт ихсээгүй /180/100 мм муб-аас ихгүй/
2	N 11 N 12	Сувганцрын завсрлын эдийн архаг нефрит	a/ Пиелит, пиелонефритийн хурц үеэс 3 сар өнгөрсөн б/ Архаг пиелит, пиелонефритийн бүрэн бус намжмал болон намжмал үе:артерийн даралт хэт ихдээгүй, бөөрний дутагдлын шинж илрээгүй
3	N30	Цистит	Архаг хэлбэр, бүрэн бус, бүрэн намжмал үе
4	N41	Түрүү булчирхайн үрэвсэл	Архаг хэлбэр, бүрэн бус, бүрэн намжмал үе
5	N70 N71	Өндгөвч, умайн архаг үрэвсэл	Архаг үрэвслийн бүрэн бус, бүрэн намжмал үе
6	N 95	Цэвэрших үеийн хямрал	Хөнгөн, дунд явцтай
7	N 97	Эмэгтэйн үргүйдэл	Аарцгийн эрхтний үрэвсэлт өвчин, умайн дутуу хөгжлийн улмаас үүссэн үргүйдэл
8	N 99 N 39	Шээс, бэлгэсийн эрхтний мэс заслын дараахь үе	Умай, өндгөвч, дайвар, түрүү булчирхайн мэс засал хийснээс 2 сараас доошгүй хугацаа өнгөрсөн, нэвчдэс,наалдац үүссэн

### Яс булчин, үе, холбогч эдийн өвчин

1	M 02 M 05-08 M 13	Үений эмгэг /артрит, артропати/	a/ Сүрьеэгээс бусад халдварын шалтгаант үений урвалжит артропати эмгэгийн намжмал болон бүрэн бус намжмал үе б/ Хэрх төст үений үрэвслийн намжмал үе үений хөдөлгөөний хязгаарлалт II зэргээс хэтрээгүй в/ Бусад шалтгаант үений үрэвсэл: үрэвслийн намжмал, бүрэн бус намжмал
---	-------------------------	---------------------------------	--

2	<b>M 15-19</b>	Артроз	а/Үрэвсэл хавсраагүй б/Хөдөлгөөний хэт хязгаарлалт үүсээгүй, хүндрэлгүй
3	<b>M 42</b>	Нурууны остеохондроз	Хүндрэлгүй
4	<b>M 45 M 47</b>	Спондилопати	а/ Спондилит: намжмал болон, бүрэн бус намжмал үе, бие даасан хөдөлгөөн алдагдаагүй б/ Спондилез: хөдөлгөөний хэт хязгаарлалт үүсээгүй
5	<b>M54</b>	Дорсальги /нуруу өвдөх/	Хурцавтар, архаг хэлбэр, мэс засал эмчилгээ заалтгүй
6	<b>M 60,61 M 65 M 75-79</b>	Зөөлөн эдийн эмгэг	Миозит, периартрит, синовит, бурсит тендинитийн архаг хэлбэр бүрэн, бүрэн бус намжмал үе
7	<b>M 84</b>	Ясны хугарал	Бороожилт, ясжилт удааширсан
8	<b>M 86</b>	Ясны үрэвсэл	Сүрьеэгийн бус гаралтай, мэс засал, эмчилгээ шаардлагагүй, архаг хэлбэр

#### Арьсны өвчин

1	<b>L 20- L 30</b>	Нейродермит	Архаг хэлбэр
2	<b>L 28.2</b>	Намарс	Архаг хэлбэр
3	<b>L 40</b>	Хайрст үлд	Энгийн тархмал болон хязгаарлагдмал, артропати хавсарсан
4	<b>L 43</b>	Хавтгай ширшил үлд	Архаг хэлбэр
5	<b>L 50</b>	Чонон хөрвөс	
6	<b>L 70</b>	Батга	Архаг хэлбэр
7	<b>L 94</b>	Склеродерми	

#### Дотоод шүүрэл, бодисын солилцооны өвчин

1	<b>E 66</b>	Таргалалт	Дотоод шүүрлийн бус гаралтай
2	<b>E 10 E 11</b>	Чихрийн шижин	Хөнгөн дунд хэлбэр

**ХОЁР. РАШААН СУВИЛЛЫН КЛИНИК ТАСАГТ**  
**ЭМЧЛЭХ ӨВЧНИЙ ЖАГСААЛТ**

<b>№</b>	<b>Олон улсын ангиллын код</b>	<b>Өвчний нэр</b>	<b>Сувилалд эмчлэх өвчний үе шат онцлог</b>
1	I 21	Зүрхний булчингийн шигдээс	a/ Өвчин хурц үедээ хүндрээгүй анхдагч ба дахисан жижиг голомтот шигдээсээр өвчилснөөс хойш 1 сарын дараа б/ Анхдагч ба дахисан том голомтот шигдээсийн хурц үе өнгөрснөөс хойш 1,5-2 сарын дараа в/ Зүрхний булчингийн шигдээс өвчний эдгэрэх шат: титэм судасны архаг дутмагшилтай, цусны эргэлтийн дутмагшил II A үеэс хэтрээгүй, артерийн даралт ихдэх өвчин I-II шатанд байх, зүрхний хэм, дамжуулах чадвар алдагдлын хүнд хэлбэргүй байх
2	I 97	Зүрхний мэс ажилбарын дараахь үе	a/ Мэс ажилбарын дараа 1-6 сар өнгөрсөн, хэрэх өвчний идэвхжилгүй, цусны эргэлтийн дутмагшил II A үеэс хэтрээгүй
3	G 45	Тархины цусны эргэлтийн түр зуурын хямрал	Тархины цусны эргэлтийн түр зуурын хямралын дараахь үе
4	I 60 I 61 I 63	Тархины цус харвалт, шигдээс	Цус харвасан болон тархины шигдээсийн дараа 1,5-2 сараас доошгүй хугацаа өнгөрсөн, артерийн даралт тогтвортой, бусад хүндрэлгүй, сэтгэц хэвийн, өөртэй үйлчлэх чадвар сэргэж буй үе
5	G 97	Мэдрэлийн мэс ажилбарын дараахь үеийн эмгэг	a/ Тархинд цус харваснаас хийсэн мэс ажилбарын дараа 1,5-2 сараас доошгүй хугацаа өнгөрсөн, шарх эдгэрсэн, артерийн даралт тогтвортой, бусад хүндрэлгүй, өөртөө үйлчлэх чадвар сэргэж байгаа
6	K25 K26	Ходоод, дээд гэдэсний шархлааны идэвхжилт буурсан болон намжмал үе, үйл ажиллагааны алдагдалгүй, цус алдалт бусад хүндрэл илрээгүй	Ходоод, дээд гэдэсний шархлаанд мэс засал хийсний дараахь эрт үе: үрэвсэл, халдварт, хүндрэлийн шинж илрээгүй байх
7	K91	Хоол боловсруулах эрхтний мэс заслын	a/ Ходоод, дээд гэдэсний шархлаанд мэс засал хийсний дараахь эрт үе: үрэвсэл, халдварт, хүндрэлийн шинж илрээгүй байх б/ Цөсний замд мэс засал хийлгэсний дараахь эрт үе:

		дараахь үе	үрэвсэл, халдварт, хүндрэлийн шинж илрээгүй байх
8	N 99	Шээс, бэлгэсийн эрхтний мэс заслын дараахь үе	a/ Умай, дайвар, өндгөвчний мэс заслын дараахь эрт үе, үрэвсэл, хүндрэлгүй б/ Бөөрний мэс заслын дараахь эрт үе: хагалгааны шарх эдгэрч буй, үрэвсэл хүндрэлийн шинж илрээгүй в/ Түрүү булчирхайн мэс заслын дараах үе, шарх эдгэрч байгаа, үрэвсэл, хүндрэлгүй г/ Эм бэлэг эрхтэн унжих эмгэгийн мэс заслын дараахь эрт үе, үрэвсэл, хүндрэлгүй
9	G 51	Нүүрний мэдрэлийн эмгэг	Стационарны дараахь эрт үе
10	G 55	Нугалам хоорондын эвэрхий авах мэс заслын дараахь үе	Ламиноэктомии хагалгааны дараа өөртөө үйлчлэх, бие даан хөдлөх чадвартай байх
11	E 07	Бамбайн булчирхайн мэс заслын дараахь үе	Хагалгааны дараахь эрт үе: үрэвсэл хүндрэл, хордлогын шинж илрээгүй
12	T 84.0	Дотор хиймэл үений механик хүндрэл	Хиймэл үе суулгах мэс ажилбарын дараахь үе, халдварт, үрэвслийн хүндрэлгүй, өөртөө үйлчлэх, бие даан хөдлөх чадвартай

--- о О о ---

**ГУРАВ. РАШААН, СУВИЛАЛД ЭМЧЛЭХ, СУВИЛАХАД  
ХОРИГЛОХ ЭМГЭГҮҮД**

1	<b>Амьсгалын замын эрхтний эмгэг</b>	Зүрх, амьсгалын дутмагшил II үеэс дээш хүндрэлтэй амьсгалын эрхтний өвчин
		Их хэмжээний идээт цэр ялгаралттай бронхоэктази, архаг буглаа
		Гуурсан хоолойн багтрааны сэдрэлийн үе
		Цустай цэр ялгарч буй өвчин
		Гялтанд шингэн үүссэн өвчин
2	<b>Зүрх судасны эрхтний эмгэг</b>	Бүх төрлийн сүрьеэз
		Хэрх гаралтай эндомиокардит идэвхжлийн үед
		Зүрхний шигдээсийн хурц үе
		Тогтвортой бус зүрхний бах III, IV ү.а.б
		Зүрх судасны дутмагшил IIA үеэс дээш
		Зүрхний хэм алдагдлын хүнд хэлбэр
		Артерийн даралт ихдэх өвчиний III шат
3	<b>Хоол шингээх эрхтэн, тогтолцооны эмгэг</b>	Захын судасны үрэвслийн тархмал, үжил үүссэн хүнд хэлбэр
		Зүрх, гол судас, судасны аневризм
		Хоол боловсруулах эрхтнүүдийн өвчиний хурц, сэдрэлийн үе
		Цус алдалт, цооролт, хавдарт шилжиж буй хүндрэл бүхий ходооодны шарх, шархны сэдрэл
		Сорвижилтоос үүссэн улаан хоолойн нарийсал
		Ходоодны хагалгааны дараах хүндрэлүүд
		Архаг цусан суулгалт, гэдэсний шархлаат үрэвсэл
		Идэвхжилттэй элэгний үрэвсэл
		Элэгний цирроз
		Шарлах хам шинж бүхий элэгний архаг
4	<b>Мэдрэлийн тогтолцооны эмгэг</b>	Нойр булчирхайн үрэвслийн хүнд хэлбэр
		Мэдрэлийн тогтолцооны өвчиний хүнд, хурц хэлбэр
		Хөдөлгөөн, мэдрэхүйн алдагдал, саажилтын улмаас өөртөө үйлчлэх чадваргүй, аарцгийн эрхтний үйл ажиллагаа алдагдсан эмгэг
		Эпилепси уналт
		Сэтгэцийн өөрчлөлт илэрсэн байдал
5	<b>Бөөр, шээсний зам, бэлгийн замын эмгэг</b>	Бөөрний дутагдал бүхий өвчин
		Макрогемотури илрэлтэй өвчнүүд
		Мэс заслын эмчилгээ шаардлагатай бөөрний чулуу
		Шээс дамжуулах замын нарийсал
		Эмэгтэйчүүдийн хавдрын урьдал өвчин

		Өндгөвч, умайн хүзүү, умайн хоргуй хавдар Эмэгтэйсүүдийн дисфункциональ цус алдалт
6	<b>Дотоод шүүрэл бодисын солилцооны өвчин</b>	Хордлогот бамбай Бамбай булчирхайн дутмагшил Чихрийн шижин декомпенсацийн шатанд Дотоод шүүрлийн эрхтний хавдрын гаралтай таргалалт Таргалалтын III-IV зэрэг зүрх, судасны дутмагшил II шатнаас дээш хавсарсан
7	<b>Нүд ба түүний дайврын эрхтний эмгэг</b>	Нүдний даралт ихдэх өвчин
8	<b>Бусад</b>	Бүх өвчний хурц үе, архаг өвчний хурцдлын үе, идээт процесс Хурц халдварт өвчин Нян тээгч тогтоогдсон тохиолдол Арьс, өнгөний халдварт өвчний халвар тараах, сэдрэлийн шат Сэтгэцийн өвчин, архи, мансууруулах бодист донтолч Цусны өвчин Хорт хавдар Стационарын эмчилгээний дараах өөртөө үйлчлэх, бие даах чадвар сэргээгүй тохиолдол Байнгын давтддаг цус алдалт, цус алдах магадлалтай өвчин Тураал Жирэмсэн

--- о О о ---

Эрүүл мэндийн сайдын <sup>2011</sup> оны  
7 дугаар сарын <sup>2011</sup> ёдрийн <sup>2011</sup> тоот  
тушаалын гуравдугаар хавсралт

Маягт- РСМ №3А

## РАШААН, СУВИЛАЛД ИЛГЭЭХ БИЧИГ

20 ... он ... сар ... ёдөр

Дугаар \_\_\_\_\_

1. Илгээх бичиг олгосон эмнэлгийн нэр .....
2. Сувилуулагч..... овогтой .....
5. Нас: ... 4. Хүйс ... 5. Оршин суугаа хаяг.....  
.....  
.....
6. Ажлын газрын хаяг: .....
7. Ажил, албан тушаал: ..... 8. Мэргэжил .....
9. Утасны дугаар ..... Ар гэртэй нь холбоо барих утасны дугаар .....
10. Сувилуулагчийн зовиур, бодит үзлэг, анамнез, хийгдсэн эмчилгээ , шинжилгээ:  
.....  
.....  
.....  
.....
- 11.Онош: Үндсэн .....
- Дагалдах .....
- 12.Рашаан, сувиллын нэр: .....
- 13.Сувилуулах хоног: .....

Тамга

Дарга /Ерөнхий эмч/.....  
Эмчлэгч эмч.....

Эрүүл мэндийн сайдын ... оны  
... дугаар сарын ... ёдрийн ... тоот  
тушаалтын дөрөвдүгээр хавсралт

PCM № 1 (a)

Харшиилдаг эм, хоол, хүнс .....

СУВИЛУУЛАГЧИЙН ТҮҮХ

НДД № .....  
ЭМД № .....  
Паспорт № .....  
Регистр № .....  
Сувилуулах бичгийн № .....

1. Овог нэр .....
2. Нас ..... 3. Эрэгтэй, эмэгтэй (зур)  
4. Яс, үндэс
5. Тогтол хаяг: .....
6. Ажлын газар: .....
7. Албан тушаал: .....
8. Мэргэжил: .....
9. Боловсрол: (дээд, дунд, бааг) /зур/  
10. Утас: ..... ар гэрийн .....
11. Хэвтсэн: 20 ... он сар ... ёдэр ... цаг
12. Гарсан, шилжсэн, хугацаанаас өмнө  
бучсан /зур/ 20 ... он ... сар ... ёдэр
13. Ор хоног

Өрөө № ...  
Эмчлэгч эмч .....

Сувилалд ирүүлсэн эмнэлгийн нэр: .....

Сувилалд ирүүлсэн онош: .....

Сувиллын онош: .....

20 ... оны ... сарын ... өдөр ... цаг ... МИН  
Хэвтэх үеийн зовиур:

Өвчиний түүх:

Амьдралын түүх:

Эпид анамнес: сурьеэз /, гепатит /, корь /, салхин цэцэг /, гахай хөвдэр /, гэдээсний халдвэр /,  
Н1N1 вирусын халдвэр /, шинэ вирусын халдварууд /, хавьтсан эсэх /  
Суплийн 3 сар гадаад оронд зорчсон эсэх /

A) Үзлэг:

Биеийн байдал: /зур/ хөнгөн, дунд зэрэг, хүндээвтэр, хүнд  
Байрлал: /зур/ идэвхитэй, идэвхийг, албадмал  
Арьс, салстын өнгө: /зур/ хэвийн, улаан, шарангуй, хөхөлбөр  
Чийгзг: /зур/ хэвийн, ихэссэн, баgассан  
Арьс: /зур/ тууралттай, тууралтгүй  
Шархны байдал: /status localis/

Марианы байдал: /зур/ өрдийн, таргандуу, тарган, туранхайтар, туранхай, хэм туранхай  
Хаван: /зур/ өрөнхий, нүүр, зөвхүү, хэвлэй, шилбээр  
Захын тунгалагийн булчирхай: /зур/ хэвийн, томорсон

- Амьсгалын эркэтний тогтолцоо**  
Цээжний хэлбэр: зөв, зөв бус; амьсгалын хэм 2 талд: жигд, жигд бус; амьсгалын тоо: 1 мин ... удаа  
Үндсэн шуугиан: цулцангийн, гурсан хоолойн; ЭМТЭГ шуугиан: \_\_\_\_\_
- Цусны эргэлтийн тогтолцоо**  
Зурхий авиа: тод, буудээ, буудгаатээр; хэм: жигд, жигд бус; хэм алдант хэлбэр \_\_\_\_\_  
Судасны цохильтын тоо: 1 мин ... удаа; хүчдэл дүүрэлт \_\_\_\_\_; АД \_\_\_\_\_
- Хоол шингээх эрхтэн тогтолцоо**  
Хэлний ёнгө: \_\_\_\_\_; хамгийн тэмтрэлтээр /зур/: эмзэглэлгүй, эмзэглэлтэй; энгэр \_\_\_\_\_; Эмзэглэлийн байрлал \_\_\_\_\_
- Хэвлэлийн хэмжээ тэмтрэлтээр /зур/:** а) хэвийн б) томорсон  
Элэтний хэмжээ тэмтрэлтээр /зур/: а) хэвийн б) томорсон  
Цэсний овдөглийн үед илрэх шинж \_\_\_\_\_  
Нийр булчирхайн овдөлтийн үед илрэх шинж \_\_\_\_\_  
Өтгөн /зур/: хэвийн, суулгана, хатна \_\_\_\_\_
- Шээс ялагуулах тогтолцоо**  
Пастернацкии шинж баруун / , зүүн / ; хоногийн шээсний гарц: хэвийн, ихэссэн, баатассан; ёнгө: \_\_\_\_\_, шене шээдэг, угүй; шээхэд өвдөөг, угүй; дулгуулж гардаг, угүй;  
**Үе мөч, багана нуруу**  
Хэлбэр /зур/: өөрчлөгдсөн, хавдсан, өвдөлтэй, булчин чангарсан /аль үе, хэсээт/ \_\_\_\_\_
- Хөдөлгөөн:** идэвхтэй, чөлөөтэй, идэвхгүй, хязгаарлагдмал /аль үен/ \_\_\_\_\_
- Мэдрэлийн тогтолцоо /өөрчлөлтийг бич/**  
Бусад: \_\_\_\_\_  
Шинжилгээ: \_\_\_\_\_  
Онош: \_\_\_\_\_

<b>Сувилуулагчийн биесийн байдал, тэмдэглэл</b>	<b>Заалт</b>
	<ol style="list-style-type: none"><li>1. Хооп № .....</li><li>2. Дэглэм .....</li><li>3. Рашаан уух хоолноос ..... минутын ёмнө, ..... мл-эр, ёдөрт .... удаа, шимж, балгаж, заптигж /зур/ ууна.</li></ol>

<p><b>Сувилуулагчийн биеийн байдал, тэмдэглэл</b></p>	<p><b>Заалт</b></p>

28

**Гарах:** Эмнэлэгт шилжсэн; хугацаанаас өмнө гарсан /зур/  
үеийн эпикриз 20 ...оны ...-р сарын ... өдөр ..... цаг ... мин

Сувилуулагч ..... овогтой  
20 ...оны ... -р сарын ... өдрөөс 20 ... оны ... р сарын ... өдөр хүртэл ..... хоног сувилуулав.

**Хийгдсэн эмчилгээ, тоо /**: рашидан уух ..., рашианд орох ..., иллэг ..., бумба ..., биеийн тамир ...,  
усан эмчилгээ ..., шавар ..., парафин ..., цөс угаах ..., гэдэс угаах ..., хүзүү, нуруу татлага..., зүй ...,  
физик эмчилгээ.

**Эмчилгээний үр дун: Биеийн байдал: илт сайжирсан, сайжирсан хэвдээ, дордсон /зур/**

**Гарах үед өгсөн зөвлөмж:**  
Эмчилгээний дараах гам сахих / /, АД-г хянах / /, Зөв холпох / /, Давтан шинжилгээ хийгдэх / /,  
эмчийн хяналтанд байх, бусад:

**A. Гарах үеийн сувиллын онوش:**

**Б. Дагалдах онوش:**

**В.Хүндэрл:**

Эмчилгэч эмч: .....  
Тасгийн эрхлэгч: .....  
Хүлээн авсан статистик эмч: .....